

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/171-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn</p> <p>Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: “Пийк Ом Аудит” ХХК Утас: 99862066 Цахим хаяг: peakomaudit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт.....	20
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Селэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.08.25 № 01А 2022/171-НА-ЕР-ТШЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	240,561,377.35	226,006,990.50
33	АВЛАГА	698,945.00	698,945.00
33500	Бусад авлага	698,945.00	698,945.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	698,945.00	698,945.00
35	БАРАА МАТЕРИАЛ	239,862,432.35	225,308,045.50
35100	Түүхий эд материал	472,000.00	280,000.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	0.00
35130	Эм боох материал	472,000.00	280,000.00
35400	Хангамжийн материал	239,390,432.35	225,028,045.50
35410	Бичиг хэргийн материал	1,970,120.00	11,952,378.20
35420	Аж ахуйн материал	175,359,879.47	178,491,184.42
35450	Барилгын засварын материал	2,811,500.00	8,109,357.00
35460	Хүнсний материал	906,450.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	58,342,482.88	26,475,125.88
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,877,803,199.25	2,774,839,357.34
37330	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,877,803,199.25	2,774,839,357.34
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	2,843,676,199.25	2,734,032,357.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,821,815,400.00	2,821,815,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-204,962,743.32	-308,183,046.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,802,400.00	59,802,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25,398,284.58	-29,946,465.14
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	243,647,573.85	243,950,863.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	-125,227,310.46	-147,005,315.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,058,520.00	129,062,911.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74,557,691.76	-68,614,361.24
39214	Бусад үндсэн хөрөнгө	52,806,776.58	52,523,180.58
39215	Хуримтлагдсан элэгдэл	-23,037,690.72	-23,102,459.76
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	3,729,249.66	3,729,249.66
39300	Биет бус хөрөнгө	34,127,000.00	40,807,000.04
39301	Програм хангамж	2,552,430.00	9,482,430.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,302,430.00	-1,552,429.96
39303	Бусад биет бус хөрөнгө	32,877,000.00	32,877,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,118,364,576.60	3,000,846,347.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	199,447,732.00	263,988,402.32
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	199,447,732.00	263,988,402.32
41300	Өглөг	199,447,732.00	263,988,402.32
41360	Бусад өглөг	199,447,732.00	263,988,402.32
41361	Байгууллагад төлөх өглөг	199,447,732.00	263,988,402.32

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,918,916,844.60	2,736,857,945.52
51	Засгийн газрын хувь оролцоо	2,918,916,844.60	2,736,857,945.52
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	519,308,098.80	519,308,098.80
51200	Хуримтлагдсан үр дүн	-736,611,886.21	-918,670,785.29
51210	Өмнөх үеийн үр дүн	-787,278,354.16	-736,611,886.21
51220	Тайлант үеийн үр дүн	50,666,467.95	-182,058,899.08
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,136,220,632.01	3,136,220,632.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,118,364,576.60	3,000,846,347.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,713,939,062.68	1,531,689,954.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	184,882,646.41	44,213,220.25
120	Нийтлэг татварын бус орлого	184,882,646.41	44,213,220.25
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	105,315,601.66	21,679,903.05
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	79,567,044.75	22,533,317.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,529,056,416.27	1,487,476,734.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,288,121,200.00	1,210,560,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,288,121,200.00	1,210,560,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,305,173.27	34,038,234.71
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	17,026,644.71
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	11,627,980.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,305,173.27	5,383,610.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	235,630,043.00	242,877,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	235,630,043.00	242,877,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,663,272,594.73	1,692,068,950.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,663,272,594.73	1,692,068,950.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,602,195,068.73	1,653,845,400.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,043,741,685.00	1,003,900,300.00
210101	Үндсэн цалин	699,888,275.00	656,477,540.60
210102	Нэмэгдэл	302,002,528.00	284,974,694.40
210104	Урамшуулал	41,850,882.00	62,448,065.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,315,519.00	132,480,400.00
210201	Тэтгэврийн даатгал	92,349,316.00	87,053,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,758,660.00	10,042,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,366,000.00	8,034,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,588,563.00	2,008,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,252,980.00	25,341,600.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	257,456,513.00	306,972,870.32
210301	Гэрэл, цахилгаан	10,354,347.00	9,157,775.00
210302	Түлш, халаалт	237,254,319.00	290,309,366.32
210303	Цэвэр, бохир ус	9,847,847.00	7,505,729.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,386,463.27	46,229,551.00
210401	Бичиг хэрэг	4,561,642.00	22,671,918.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	260,000.00	920,000.00
210404	Ном, хэвлэл	8,500.00	9,177,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,300.00	688,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,706,021.27	11,471,933.00
2105	Нормативт зардал	697,000.00	3,671,034.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	697,000.00	962,600.00
210502	Хоол, хүнс	0.00	1,598,434.71
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	1,110,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,780,500.00	3,546,250.00
210604	Урсгал засвар	1,780,500.00	3,546,250.00
2107	Томилолт, зочны зардал	553,200.00	545,300.00
210702	Дотоод албан томилолт	553,200.00	545,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	959,400.00	7,211,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	95,400.00	6,059,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	1,152,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,304,788.46	149,287,744.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	206,800.00	5,129,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	143,097,988.46	144,158,744.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,077,526.00	38,223,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,698,680.00	38,215,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,333,680.00	37,415,550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,365,000.00	800,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,378,846.00	8,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,378,846.00	8,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	50,666,467.95	-160,378,996.03
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	21,679,903.05
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.00	21,679,903.05
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	50,666,467.95	-182,058,899.08

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,529,056,416.27	1,487,476,734.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,529,056,416.27	1,487,476,734.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,288,121,200.00	1,210,560,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,288,121,200.00	1,210,560,700.00

131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,305,173.27	34,038,234.71
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	17,026,644.71
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	11,627,980.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,305,173.27	5,383,610.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	235,630,043.00	242,877,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	235,630,043.00	242,877,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,508,506,416.27	1,467,961,734.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,508,506,416.27	1,467,961,734.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,446,371,920.27	1,430,644,634.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,045,746,600.00	1,003,900,300.00
210101	Үндсэн цалин	684,212,200.00	657,440,700.60
210102	Нэмэгдэл	281,369,800.00	284,011,534.40
210104	Урамшуулал	80,164,600.00	62,448,065.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,310,604.00	132,480,400.00
210201	Тэтгэврийн даатгал	95,702,000.00	92,308,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,820,271.00	10,042,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,366,000.00	8,034,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	281,785.00	2,008,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,140,548.00	20,085,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,391,143.00	242,432,200.00
210301	Гэрэл, цахилгаан	10,354,347.00	9,157,775.00
210302	Түлш, халаалт	215,188,949.00	225,768,696.00
210303	Цэвэр, бохир ус	9,847,847.00	7,505,729.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,718,673.27	23,626,120.00
210401	Бичиг хэрэг	818,400.00	4,887,348.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	768,500.00	920,000.00
210404	Ном, хэвлэл	741,100.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,612,200.00	1,044,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,978,473.27	15,474,772.00
2105	Нормативт зардал	2,642,500.00	3,393,134.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	365,700.00	352,600.00
210502	Хоол, хүнс	813,800.00	1,598,434.71
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,463,000.00	1,442,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,548,500.00	8,810,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	2,327,000.00
210602	Тавилга	0.00	411,900.00
210604	Урсгал засвар	3,548,500.00	6,071,300.00
2107	Томилолт, зочны зардал	553,200.00	545,300.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	553,200.00	545,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,952,400.00	9,686,930.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,088,400.00	8,534,930.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	1,152,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,508,300.00	5,770,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,322,100.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,186,200.00	5,770,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,134,496.00	37,317,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,755,650.00	37,309,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,255,650.00	36,509,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	800,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,378,846.00	8,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,378,846.00	8,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,550,000.00	19,515,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	20,550,000.00	19,515,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,550,000.00	19,515,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,550,000.00	19,515,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,550,000.00	19,515,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-20,550,000.00	-19,515,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,308,098.80	3,136,220,632.01	-787,278,354.16	2,868,250,376.65
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	519,308,098.80	3,136,220,632.01	-787,278,354.16	2,868,250,376.65
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	50,666,467.95	50,666,467.95
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,308,098.80	3,136,220,632.01	-736,611,886.21	2,918,916,844.60
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	519,308,098.80	3,136,220,632.01	-736,611,886.21	2,918,916,844.60
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	519,308,098.80	3,136,220,632.01	-736,611,886.21	2,918,916,844.60
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-182,058,899.08	-182,058,899.08
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	519,308,098.80	3,136,220,632.01	-918,670,785.29	2,736,857,945.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант оны		Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,453,438,500.00	1,453,430,500.00	8,000.00	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,453,438,500.00	1,453,430,500.00	8,000.00	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,416,129,400.00	1,416,121,400.00	8,000.00	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,003,900,300.00	1,003,900,300.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	657,440,700.00	657,440,700.60	-0.60	100.0
210102	Нэмэгдэл	289,114,500.00	284,011,534.40	5,102,965.60	98.2
210104	Урамшуулал	57,345,100.00	62,448,065.00	-5,102,965.00	108.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,480,400.00	132,480,400.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	92,308,800.00	92,308,800.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	10,042,900.00	10,042,900.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,034,300.00	8,034,300.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,008,600.00	2,008,600.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	20,085,800.00	20,085,800.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	242,432,200.00	242,432,200.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	12,824,000.00	9,157,775.00	3,666,225.00	71.4
210302	Түлш, халаалт	216,152,900.00	225,768,696.00	-9,615,796.00	104.4
210303	Цэвэр, бохир ус	13,455,300.00	7,505,729.00	5,949,571.00	55.8
2104	Хангамж, бараа материалын зардал	9,173,200.00	9,173,200.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	806,700.00	2,596,840.00	-1,790,140.00	321.9
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	757,500.00	100,000.00	657,500.00	13.2
210404	Ном, хэвлэл	1,130,500.00	0.00	1,130,500.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	896,400.00	563,000.00	333,400.00	62.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,782,100.00	5,113,360.00	-331,260.00	106.9
2105	Нормативт зардал	1,802,600.00	1,794,700.00	7,900.00	99.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	360,500.00	352,600.00	7,900.00	97.8
210502	Хоол, хүнс	0.00	0.00	0.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,442,100.00	1,442,100.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,471,300.00	22,471,300.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,400,000.00	16,400,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	6,071,300.00	6,071,300.00	0.00	100.0

2107	Томилолт, зочны зардал	545,300.00	545,300.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	545,300.00	545,300.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,927,000.00	1,926,950.00	50.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	775,000.00	774,950.00	50.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,397,100.00	1,397,050.00	50.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,397,100.00	1,397,050.00	50.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,309,100.00	37,309,100.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,309,100.00	37,309,100.00	0.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,509,100.00	36,509,100.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,453,438,500.00	1,453,438,500.00	0.00	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,210,560,700.00	1,210,560,700.00	0.00	100.0
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,210,560,700.00	1,210,560,700.00	0.00	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	242,877,800.00	242,877,800.00	0.00	100.0
320001	Орон нутгийн төсвөөс	242,877,800.00	242,877,800.00	0.00	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	81	81	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	5	5	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	57	57	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	19	19	0.0	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,115	1,115	0.0	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	1,115	1,115	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,038,234.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,596,234.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,596,234.71
2104	Хангамж, бараа материалын зардал	14,452,920.00
210401	Бичиг хэрэг	2,290,508.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	820,000.00
210404	Ном, хэвлэл	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	481,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,361,412.00
2105	Нормативт зардал	1,598,434.71
210502	Хоол, хүнс	1,598,434.71
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	411,900.00
210602	Тавилга	411,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,759,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,759,980.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,373,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,373,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,442,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,442,000.00
223001	Бусад хөрөнгө	5,442,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,038,234.71
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,038,234.71
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,026,644.71
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,627,980.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,383,610.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн /цаашид Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, ажил гүйлгээг батлагдсан загвар баримт, аргачлалын дагуу хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:

Тус сургууль нь “Хүүхдийн хөгжлийг тасралтгүй дэмжиж, хичээл сургалтын үйл ажиллагааг хосолсон хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулж хоцрогдлыг нөхөх, арилгахад бүх талын оролцоог дэмжин ажиллах” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагч бүрийг боловсролд тэгш хамруулах, сургууль завсардахаас сэргийлэх, “Ногоон гэрэл” хөтөлбөрийг үр дүнтэй хүртээмжтэй хэрэгжүүлэх,
- Хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж цахим хичээлийн болон даалгаврын сан бүрдүүлэн ашиглах,
- Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүй, мэдлэг ур чадвараа хөгжүүлж, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх,

- Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх,
- Мэргэжил, арга зүйн байгууллага болон мэргэжлийн бүлгээр хамтран ажиллаж, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэн сургалт үйл ажиллагааны чанарыг сайжруулах,
- Ажлын байран дээрх эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бэхжүүлэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн,
- Засгийн газрын 2021 оны 237 тоот тогтоол “Үдийн хоолны норматив”
- Эрчим хүчний зохицуулах хорооны “Дулааны үнийн тариф шинэчлэн тогтоох тухай” 469 тоот тогтоол гарсан,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,663,272.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,632,7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12,474.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 117,518.2 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	698.9	698.9	-
Урьдчилгаа			-
Бараа материал	239,862.4	225,308.0	(14,554.4)
Үндсэн хөрөнгө	2,877,803.2	2,774,839.4	(102,963.8)
Нийт хөрөнгө	3,118,364.5	3,000,846.3	(117,518.2)
Өр төлбөр	199,447.7	263,988.4	64,540.70
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,918,916.8	2,736,857.9	(182,058.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,118,364.5	3,000,846.3	(117,518.2)

Бараа материалын дансны үлдэгдэл 225,308.0 мянган төгрөг болж 14,554.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 67,621.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон БШУЯ-наас 22,533.3 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй хүлээн авсан, мөн үндсэн хөрөнгийн шинж чанартай 21,679.9 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн, 83,029.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,331,563.5 мянган төгрөг болж өмнөх оноос 20,954.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 19,515.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, бараа материалын данснаас 21,679.9 мянган төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэн болон Сайхан сумын ИТХТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 31 тоот тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, дахин ашиглах боломжгүй элэгдлээ бүрэн нөхсөн 20,240.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, устгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,736,857.9 мянган төгрөг болж 182,058.9 мянган төгрөгөөр буурсан нь нийт хөрөнгийн бууралтаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 182,249.1 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн хэмжээ болон төсвийн санхүүжилтийн бууралттай холбоотой байна.

Тайлант оны нийт зардал өмнөх оноос 28,796.3 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн нь халаалтын болон хангамжийн материалын зардлууд материаллаг хэмжээгээр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,463,402.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,463,402.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 141,188.9 мянган төгрөгөөр бууруулж, 1,322,213.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Батлагдсан төсөвт 2021 оны 12-р сард Боловсролын газраас өөрчлөлт оруулан цалин, нийгмийн даатгалын зардалд 135,100.5 мянган төгрөг, хангамж, эд хогшил худалдан авах зардалд 22,734.3 мянган төгрөгийг нэмж, үдийн хоол хөтөлбөрийн зардлыг 26,619.7 мянган төгрөгөөр бууруулж нийт 131,215.2 мянган төгрөгөөр нэмж **1,453,038.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,453,038.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,210,160.7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 242,877.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,210,560.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 242,877.8 мянган төгрөгийн санхүүжилт нийт 1,453,438.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн **1,453,430.7** мянган төгрөгийг зарцуулж, тайлант оны эцэст нормативт зардлын хэмнэлт 8.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БШУЯ, Дэлхийн банк хамтран хэрэгжүүлж байгаа “Боловсролын чанарын шинэчлэл- 5” төслийн хүрээнд 28,654.5 мянган төгрөг, автобус түрээсийн орлого 5,383.6 мянган төгрөгийг нэмэлт төсвийн дансанд шилжүүлснээс 14,452.9 мянган төгрөгийг хангамж бараа материалд, 10,361.4 мянган төгрөгийг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлд, 1,598.4 мянган төгрөгийг хоол хүнсэнд, 411.9 мянган төгрөгийг тавилга эд хогшилд, 7,759.9 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид, 4,373.0 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардалд, 5,442.0 мянган төгрөгийг хөрөнгө худалдан авахад тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сургуулийн багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар

тооцож 14,874.7 мянган төгрөгийг олгосон байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын хоёрдугаар хавсралт “Короновируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээлэл байршуулахаас 112 мэдээллийг хугацаа хоцроож, 11 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Тухайлбал:

1. Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 36 удаа хугацаа хоцроож, 6 удаа огт мэдээлээгүй,
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 32 удаа хугацаа хоцроож, 2 удаа огт мэдээлээгүй,
3. Бусад мэдээллийг 44 удаа хугацаа хоцроож, 11 удаа огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн тайлант оны үйл ажиллагаанд 1,453,438.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр

1,453,430.5 мянган төгрөгийг зарцуулан, батлагдсан төсвийг 100 хувь зарцуулсан нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг зөрчсөн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,418.5 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 1 албан шаардлагыг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2,418.5	1	2,418.5	100.0
Нийт дүн	1	2,418.5	1	2,418.5	100.0

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 203,648.6 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил илэрснээс 72,986.7 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 510.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 2,244.0 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 127,907.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг хийж санхүүгийн тайланд тусгалаа.

1. 2020 оны 1 дүгээр сард БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн 39,190.0 мянган төгрөгийн физикийн кабинетын тоног төхөөрөмжийг тхооцооны дансаар дамжуулалгүй шууд орлого авч, тайлант оны эцэст зардлаар бүртгэсэн,
2. Хөрөнгө орлого авахдаа тооцооны дансаар дамжуулалгүйгээр 3,432.6 мянган төгрөгийн бараа материалыг журнал дээр шууд орлогоор бүртгэсэн,
3. Бараа материалын тайлангийн орлого, журналын орлогоос 3,947.7 мянган төгрөгөөр зөрүүтэй,
4. Үндсэн хөрөнгийн шинж чанартай 21,679.9 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн,
5. Үндсэн хөрөнгийг буруу ангилж бүртгэсэн 1,967.2 мянган төгрөг, бараа материалыг буруу ангилж бүртгэсэн 2,769.3 мянган төгрөг,

4.2 Төлбөрийн акт

1. Скайтель компанитай гэрээ хийж, гар утас зээлээр авсан багш нарын төлбөрийг 510.2 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн хөрөнгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох,

4.3 Албан шаардлага

1. Тайлант жилийн эцэст татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс татварын тайланд цалингийн санг 785.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан, багш ажилтнуудын цалингаас 1,268.2 мянган төгрөгийн ХХОАТ дутуу суутгаж өглөг, авлагын тооцоо үүсгэх эрсдэл үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно"*, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд *"Эрх ба үүрэг"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага хүргүүлэх

2. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр хамтын сангийн өглөг гэж тайлант оны батлагдсан төсвөөс 190.8 мянган төгрөгийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх *"Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ"*, 14.4.3: *"бүх өр төлбөр"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг тухай бүр нь үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас урсгал засварт 1,053.5 мянган төгрөгийг, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас халдвар хамгааллын

хувцас худалдан авахад 440.0 мянган төгрөгийг, автобус түрээсийн орлогын шимтгэлд 1,076.7 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас урсгал засварт 293.4 мянган төгрөгийг, резин бээлийн авахад 100.0 мянган төгрөгийг, бичиг хэргийн зардлаас ном худалдан авахад 400.0 мянган төгрөгийг, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас ариутгал хийсэн ажлын хөлсөнд 630.0 мянган төгрөг зэрэг нийт 3,993.6 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчиж байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

2. Анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд 89,990.7 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ*” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

3. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Захирлын 2021 оны 12 сарын 07-ний өдрийн А/24 дугаар тушаалаар томилогдсон 7 хүний бүрэлдэхүүнтэй комисс хөрөнгийн үлдэгдлийг анхан шатны бүртгэлтэй тулган шалгаж тоолоогүйгээс бараа материалын тооллогын бүртгэлийн дүн үндсэн хөрөнгө дансны үлдэгдлээс 27,788.1 мянган төгрөгөөр, бараа материалын тооллогын дүн 6,135.3 мянган төгрөгөөр зөрсөн бөгөөд зарим эд хөрөнгийг тоолж бүртгээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх “*Тооллогын комисс дараахь үүрэгтэй: 1. эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах; 2. тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн*

жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих”; 5 дахь “Тооллогын комисс дараахь эрхтэй: 1.тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас эд хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэхээр баталгаа гаргуулан авах ба нягтлан бодогч уг баримтуудыг хүлээн авсан эсэхийг шалгах”, мөн хуулийн 73 дугаар зүйлийн 2-д “ Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэж заасныг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа учир хууль тогтоомжийг биелүүлж дахин зөрчил гаргахгүй ажиллах

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сайхан сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	12	203,648.6	5	72,986.7	1	510.2	3	2,244.0	3	127,907.7